

ЭМХТ-ийн ТҮЧМИА-ны ил тод, шилэн мэдээллийн тайлан

1. 2025 онд ЭМС-ын 2017 оны А/503 дугаар тушаалын дагуу нийт 324 ЭМБ-ын МИ-ийн үнэлгээг шинжээчдийн багаар хийлгэн МИЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн.

№	ЭМБ-ийн төрөл	Нийслэл	Орон нутаг	Нийт
1.	Төрөлжсөн	3	1	4
2.	Нэгдсэн, БОЭТ	10	4	14
3.	Хувийн эмнэлэг	39	28	67
4.	Сувилал	1	9	10
5.	Сэргээн засах төв	4	1	5
6.	Өрхийн ЭМТ	51	26	77
7.	Сум, тосгоны ЭМТ	2	145	147
	Нийт	110	214	324

2. Эрүүл мэндийн 35 байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албадын үйл ажиллагаанд төвийн захирлын баталсан удирдамжийн дагуу дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээрх үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, эрсдэлийг арилгах, бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөмжийг албан бичгээр хүргүүлсэн.
3. ЭМБ-ын удирдлага, чанарын албаны мэргэжилтэн болон эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээ, шалгуур үзүүлэлтийн чиглэлээр баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу УХТЭ, ЦССҮТ, ТТАХНЭ, Улаанбаатар Сонгдо эмнэлэг, Интермед эмнэлэг, АШУҮИС-ийн төв эмнэлэг, ГҮТ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, НЭМГ, ЧДНЭ, БЗДЭМТ, БЗД-ийн 38 ӨЭМТ, 2 тосгоны ЭМТ, Хил хамгаалах ерөнхий газрын харъяа 31 ЭМБ, Булган, Хэнтий, Баянхонгор аймгийн ЭМГ, НЭ, ӨЭМТ, сумын ЭМТ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад танхим, цахим хосолсон сургалтыг 8 удаа зохион байгуулж нийт 225 гаруй ЭМБ-ын 571 албан тушаалтныг сургалтанд хамруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн.